



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2026 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/122

Улаанбаатар хот

Өрхийн эрүүл мэндийн төвд хөтлөгдөх
бүртгэлийн түр маягтын жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.19 дэх заалт, 8.10 дахь хэсэг, Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 (з), 9 дүгээр зүйлийн 9.5, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өрхийн эрүүл мэндийн төвд хөтлөгдөх бүртгэлийн түр маягтын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Эрүүл мэндийн салбарын статистикийн мэдээллийг бүртгэх, мэдээлэх тайлагнах бүртгэлийн маягт шинэчлэн батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2026 оны А/123 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягтын загвараас өрхийн эрүүл мэндийн төвд хөтлөгдөх бүртгэлийн маягтыг 2026 оны 6 дугаар сарын 01-ний өдрөөс ашиглаж эхлэхийг зөвшөөрсүгэй.

3. Өрхийн эрүүл мэндийн төвд хөтлөгдөх маягтын бүртгэх, мэдээлэх, тайлагнах, мэдээллийн сан үүсгэх, цахим хэлбэрт ашиглахад бэлэн байдлыг ханган ажиллахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв (М.Одгэрэл)-д, өрхийн эрүүл мэндийн төвийн программ хангамжийг шинэчлэх, нэгдсэн сангийн үйл ажиллагаатай уялдуулж ажиллахыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний программ хангамжид тавигдах шаардлага хангасан программ хөгжүүлэгч нарт болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Ц.Батбаатар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Туяа)-т даалгасугай.

САЙД



Э.БАТШУГАР

141260891

Эрүүл мэндийн сайдын 2026 оны
05 дугаар сарын 20 өдрийн А/182
дугаар тушаалын хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ХӨТЛӨГДӨХ
БҮРТГЭЛИЙН ТҮР МАЯГТЫН ЖАГСААЛТ

№	Бүлгийн код	Маягтын нэр	Дугаар
1.	ЭМБ-02	Жирэмсэн эмэгтэйчүүдийн бүртгэл	ЭММ-2
2.	ЭМБ-01	Хүн амын эрүүл мэндийн мэдээлэл	ЭММ-3
3.	ЭМБ-02	Эмчийн үзлэгийн бүртгэл	ЭММ-4
4.	ЭМБ-02	2 сар хүртэлх өвчтэй хүүхдийн үзлэгийн бүртгэл	ЭММ-4.1
5.	ЭМБ-02	2 сараас 5 хүртэлх насны өвчтэй хүүхдийн үзлэгийн бүртгэл	ЭММ-4.2
6.	ЭМБ-02	Амбулаторид хийгдсэн мэс засал, мэс ажилбарын бүртгэл	ЭММ-4.3
7.	ЭМБ-03	5 хүртэлх насны хүүхдийн эрт илрүүлэг үзлэгийн бүртгэл	ЭММ-4.4
8.	ЭМБ-03	6-17 насны хүүхэд, өсвөр үеийнхний эрт илрүүлэг үзлэгийн бүртгэл	ЭММ-4.5.1
9.	ЭМБ-03	Насанд хүрэгчдийн эрт илрүүлгийн бүртгэл	ЭММ-4.6.1
10.	ЭМБ-03	Хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийн бүртгэл	ЭММ-4.6.2
11.	ЭМБ-03	Урьдчилан сэргийлэх тарилгын бүртгэл	ЭММ-4.7
12.	ЭМБ-04	Халдварт бус өвчнийг мэдээлэх хуудас	ЭММ-4.8
13.	ЭМБ-04	Осол гэмтлийн шинэ тохиолдлыг мэдээлэх хуудас	ЭММ-4.10
14.	ЭМБ-02	Хүүхдийн өсөлт, хөгжлийн хяналтын бүртгэл	ЭММ-4.16
15.	ЭМБ-02	Хяналтын бүртгэл	ЭММ-4.18
16.	ЭМБ-02	Гэрээр үзүүлсэн тусламж үйлчилгээний хяналтын бүртгэл	ЭММ-4.19
17.	ЭМБ-02	Зөвшөөрлийн хуудас	ЭММ-4.22
18.	ЭМБ-01	Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ	ЭММ-5
19.	ЭМБ-02	Жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын хөтөч	ЭММ-8
20.	ЭМБ-04	Эмнэлгийн магадлагаа	ЭММ-9
21.	ЭМБ-04	Эрүүл мэндийн магадлалын зөвлөлд илгээх дүгнэлт	ЭММ-10.3
22.	ЭМБ-04	Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх бүртгэл	ЭММ-12

23.	ЭМБ-02	Өдрийн эмчилгээний түүх / насанд хүрэгч, хүүхэд/	ЭММ-14
24.	ЭМБ-02	Уламжлалт анагаах ухааны өдрийн эмчилгээний түүх	ЭММ-15
25.	ЭМБ-06	Яаралтай тусламжийн хуудас /насанд хүрэгч/	ЭММ-29.1
26.	ЭМБ-06	Яаралтай тусламжийн хуудас /хүүхэд/	ЭММ-29.2
27.	ЭМБ-06	Яаралтай тусламжийн хуудас /эх барих, эмэгтэйчүүд/	ЭММ-29.3
28.	ЭМБ-07	Энгийн эмийн жор	ЭММ-36.1
29.	ЭМБ-07	Сэтгэцэд нөлөөт эмийн жор	ЭММ-36.2
30.	ЭМБ-07	Уламжлалт эмийн жор	ЭММ-36.4
31.	ЭМБ-07	Оношилгоо, шинжилгээний дүгнэлтийн хуудас	ЭММ-37.1
32.	ЭМБ-07	Лабораторийн шинжилгээний хуудас	ЭММ-37.2
33.	ЭМБ-07	Лабораторийн шинжилгээний хариу	ЭММ-37.3
34.	ЭМБ-07	Лавлагаа шинжилгээний хариу	ЭММ-37.4
35.	ЭМБ-09	Эрүүл мэндийн байгууллагын дэд бүтэц, орчны эрүүл ахуйн үзүүлэлтийн бүртгэл	ЭМБ-1
36.	ЭМБ-09	Эрүүл мэндийн ажилчдын бүртгэл	ЭМБ-2

---o0o---